ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА

## 2023



www.1212.mn

Улаанбаатар хот
2024 он



ХЯНАСАН:
Д.Мөнхзул ЧД-ын Статистикийн хэлтсийн дарга

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:
Г.ПҮРЭВСҮРЭН ЧД-ын Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС
МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, САМБУУГИЙН ГУДАМЖ
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БАЙР
401 тоот
Утас: 976- 70113013
976- 70110767
976- 70130767
976-11-310767

Цахим хуудас: www.ubstat.mn
www.chingeltei.nso.mn
Фэйсбүүк хаяг: chingelteistatistic

И-мэйл: chingeltei@nso.mn

АГУУЛГА

ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИКИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ……………………………………………4 – 6
ЗУРГАН ТАНИЛЦУУЛГА………… ………………………………………………………………………………… 7
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ……………………………………8 – 11
ДҮГНЭЛТ ……………………………………………………………………………………………………………12 – 14

# ЭРҮҮЛ МЭНД, 2023 он

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид

| | | |
|---|---|---|
| 2022 I-XII | 9 985 | |
| 2023 I-XII | 9 063 | 9.2% ↓ |

Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид

| | | |
|---|---|---|
| 2022 I-XII | 11 086 | |
| 2023 I-XII | 1 281 | 88.4% ↓ |

Нялхсын эндэгдлийн түвшин

| | |
|---|---|
| 2022 I-XII | 0.00 |
| 2023 I-XII | 0.00 |

5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох)

| | |
|---|---|
| 2022 I-XII | 1.15 |
| 2023 I-XII | 1.3 |

## III. ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2023 онд 2246 эх амаржиж, 2255 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс төрсөн эх 343 (13.2%)-аар, мэндэлсэн хүүхэд 360 (13.8%)-аар буурсан үзүүлэлтэй байна.

ХҮСНЭГТ 1. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, 2023 байдлаар

| Үзүүлэлт | 2021 I-XII | 2022 I-XII | 2023 I-XII | Өсөлт, бууралт 2022-2023 | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Тоо | Хувь |
| Амаржсан эхийн тоо | 3 017 | 2 589 | 2 246 | -343 | -13.2% |
| Амьд төрсөн хүүхэд | 3 049 | 2 615 | 2 255 | -360 | -13.8% |
| Нас барсан хүн | 1 103 | 904 | 828 | -76 | -8.4% |
| Эхийн эндэгдэл | 3 | - | - | - | - |
| 0-1 насны нялхасын эндэгдэл | 30 | 30 | 22 | -8 | -26.7% |
| 1-5 настай хүүхдийн эндэгдэл | 4 | 3 | 3 | - | - |
| Амьгүй төрөлт | 16 | 11 | 15 | 4 | 36.4% |
| Гэрийн төрөлт | 5 | 9 | 6 | -3 | -33.3% |
| Хяналтгүй төрөлт | 11 | 2 | 12 | 10 | 5.0[1] |

*Эх үүсвэр: ЧД-ийн Эрүүл мэндийн төвийн мэдээлэл

График 1. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн өвчтөний тоо




## ҮЗЛЭГ ОНОШИЛГОО

2023 онд нийт 798846 үзлэг бүртгэгдсэний 317700 (39.8%) урьдчилан сэргийлэх үзлэг байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 24.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Үзлэгийн тоо, төрөл

| Нэршил | | 2021 | 2022 | 2023 |
|---|---|---|---|---|
| Үзлэгийн хэлбэр | Урьдчилан сэргийлэх | 208 354 | 217 524 | 317 700 |
| | Өвчний учир амбулаторит | 171 608 | 300 786 | 321 725 |
| | Гэрийн идэвхитэй үзлэг | 82 987 | 59 603 | 80 994 |
| | Гэрийн дуудлагын үзлэг | 894 | 1 346 | 4 377 |
| | Өрхийн эмчийн үзлэг | 349 243 | 358 651 | 411 029 |
| Шинээр бүртгэгдсэн | Хорт хавдар | 144 | 34 | 62 |
| | Осол гэмтэл | 200 | 119 | 196 |
| Оношний төрөл | Тохирсон | 13 | 15 | 30 |
| | Зөрсөн | 0 | 3 | 1 |

## ТӨРӨЛТ, ЭНДЭГДЭЛ

Дүүргийн хэмжээнд төрөлтийн тоо 2246 байгаа нь 2022 онтой харьцуулахад 343 (13.2%), 2021 онтой харьцуулахад 771 (25.6%) хувиар буурсан үзүүлэлтэй байна. Мөн 0-1 насны хүүхдийн эндэгдэл 22 бүртэгдэж өмнөх онтой харьцуулахад 8 (26.7%), гэрийн төрөлт 3 (33.3%) буурсан бол, хяналтгүй төрөлт 10 5 дахин өссөн байна.

Хүснэгт 3. Төрөлт, эндэгдэлийн тоо

| Төрөлт, эндэгдэлийн тоо | | 2021 | 2022 | 2023 |
|---|---|---|---|---|
| Төрөлтийн төрөл | Төрсөн эх | 3 017 | 2 577 | 2 246 |
| | Амьд төрсөн нярай | 3 049 | 2 602 | 2 255 |
| | Амьгүй төрөлт | 16 | 11 | 15 |
| | Гэрийн төрөлт | 5 | 9 | 6 |
| | Хяналтгүй төрөлт | 11 | 2 | 12 |
| Эндэгдэлийн төрөл | 0-1 насны эндэгдэл | 30 | 30 | 22 |
| | 1-5 насны эндэгдэл | 4 | 3 | 3 |
| | Эхийн эндэгдэл | 3 | 0 | 0 |

График 2. Нийслэл, дүүргийн төрөлтийн харьцуулалт



## НАС БАРАЛТ

2023 оны байдлаар Чингэлтэй дүүргийн хэмжээнд нийт 828 нас баралт бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 76 (8.4%) буурсан үзүүлэлтэй байна.

График 3. Нас баралтын тоо




График 4 Нийт төрөлт болон нас баралтын харьцаа




## ХАЛДВАРТ ӨВЧИН

2023 оны байдлаар халдварт өвчин Нийслэлийн хэмжээнд нийт 17142 байгаагаас Чингэлтэй дүүрэгт 1281 (7.4%) бүртгэгдсэн байна. Үүнээс 277 (21.6%) нь бэлгийн замын өвчин, тэмбүү 121 (9.4%), заг хүйтэн 34 (2.7%), мөөгөнцөр 20 (1.6%), трихомониаз 102 (8.0%) тус тус эзлэж байна.

Хүснэгт 3 Халдварт өвчиний төрөл, тоо

| Төрөл/Он | 2021 он | 2022 он | 2023 он | Өсөлт/Бууралт 2022-2023 | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Тоо | Хувь |
| Халдварт өвчин | 15 660 | 11 086 | 1 281 | -9805 | -88.4% |
| Гепатит | 8 | 12 | 17 | 5 | 41.7% |
| Цусан суулга | 30 | 111 | 133 | 22 | 19.8% |
| Сальмоненнез | 0 | 9 | 10 | 1 | 11.1% |
| Хоолны хордлого | 0 | 2 | 1 | -1 | -50.0% |
| Менингит | 1 | 0 | 0 | 0 | - |
| Салхин цэцэг | 16 | 84 | 396 | 312 | 3.7[1] |
| Гахайн хавдар | 0 | 0 | 10 | 10 | - |
| Улаан эсэргэнэ | 2 | 4 | 74 | 70 | 1.8[1] |
| Ёлом | 2 | 2 | 4 | 2 | 100.0 |
| Бруцеллёз | 4 | 0 | 1 | 1 | - |
| Гар, хөл, ам | 0 | 106 | 222 | 116 | 1.1[1] |
| Эритема | 0 | 0 | 2 | 2 | - |
| Хачигт риккетсиоз | 0 | 0 | 0 | 0 | - |
| Бусад | 0 | 0 | 0 | 0 | - |
| Спирохертээр сэдээгдсэн бусад халдвар | 0 | 0 | 0 | 0 | - |
| Ковид-19 | 14 884 | 10 192 | 0 | -10192 | - |
| Энтеровируст халдвар | 0 | 0 | 0 | 0 | - |
| Тэмбүү | 338 | 171 | 121 | 50 | -29.2% |
| Төрөлхийн тэмбүү | 1 | 0 | 0 | 0 | - |
| Заг хүйтэн | 70 | 53 | 34 | -19 | -35.8% |
| Сүрьеэ | 165 | 207 | 133 | -74 | -35.7% |
| Мөөгөнцөр | 35 | 30 | 20 | -10 | -33.3% |
| Трихомониаз | 108 | 103 | 102 | -1 | -1.0% |
| ХДХВ/ДОХ | 0 | 0 | 0 | 0 | - |

Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.


ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО
СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН
Хайх ...
СТАТИСТИКИЙН мэдээллээ аваарай
Data lab
тоололго судалгааны микро мэдээллийн сан
Social network
/StatisticMGL
Лавлах утас
1900-1212
Цахим шуудан
information@nso.mn

.